



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг
сайжруулах зарим арга хэмжээний тухай

Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм”-ийн хэрэгжилтийг хангуулах, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар” MNS ISO 45001:2018 стандартыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэн тогтвортой үйл ажиллагааг хангах, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг сайжруулах зорилгоор төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт ДААЛГАХ нь:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасны дагуу (Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас, аж ахуйн нэгж, байгууллага эрсдэлийн түвшнээс хамааран үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд тус тус зарцуулна) холбогдох зардлыг энэ хуулийн 26.5-д заасан арга хэмжээнд зарцуулахыг;

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-д заасны дагуу “Салааны захирагч, бүлгийн дарга, аврах ажиллагааны зааварлагч, аврагч, гал сөнөөгч, химичин аврагч, тэсэлгээчин, гал унтраах автомашины жолооч зэрэг албан тушаалтанд “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”-г мэргэжлийн байгууллагатай хамтарч хийхийг;

3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм” болон холбогдох хууль тогтоомж, стандарт, норм дүрмийн талаарх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтарч нийт алба хаагчдад зохион байгуулж, сургалтаар бататгасан мэдлэгээр шалгалт авч, баталгаажуулан, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг;

4. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо-Шаардлага, хэрэглэх заавар” MNS ISO 45001:2018 стандартын хэрэгжилтийг хангахыг;

5. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, техник хэрэгсэл хариуцсан мэргэжилтэн, эмч-сэтгэл зүйч нарыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургагч багшийн сургалтад суралцах зардлыг шийдвэрлэн суралцуулахыг;

1425020001

6. Алба хаагчдын үйлдвэрлэлийн осолд өртсөн мэдээллийг тухай бүрт нь, даатгалын байгууллагын үйлдвэрлэлийн ослын бүртгэлийн мэдээг улирал бүр нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, хяналт, дүн шинжилгээ, үнэлгээ хийн, үүрэг чиглэл өгч нэгдсэн сан үүсгэхийг;

7. Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам”-ын дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, улирлын тайлан мэдээг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлэхийг;

8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2-д зааснаар нийт алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-ээс доошгүй удаа хамруулах, шаардлагатай алба хаагчдад мэргэжлээс шалтгаалсан өвчин илрүүлэх үзлэг хийлгэх, халдварт болон халдварт бус өвчний илрүүлгийг сайжруулах, мэдээллийн санг баяжуулах, үзлэгээр илэрсэн тэргүүлэх өвчлөлийг бууруулах, хяналт тавих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг цаг хугацаанд ирүүлэхийг,

9. Алба хаагчдын хөдөлмөрийн орчин, ажлын байрны эргономик шаардлагыг хангах, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлийг бууруулах зорилгоор тохиромжтой тоног төхөөрөмж, ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах арга хэмжээ авахыг;


10. Товлолт дархлаажуулалтад хамруулах, алба хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхийг;

11. Хоол үйлдвэрлэлд холбогдох хууль тогтоомж, стандарт, болон эрүүл ахуйн шаардлагыг хэрэгжүүлэх, мэргэжлийн хоол зүйчтэй хамтран ажиллах, алба хаагч бүрийг хувьдаа ашиглах зориулалтын хоолны хэрэглэлтэй болгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг;

12. Алба хаагчдын сэтгэлзүйн байдлыг тогтмол тандалт судалгаагаар үнэлж, дүгнэлт гаргах, гамшиг, аюулт үзэгдэл, осол, гал түймрийн дуудлагад үүрэг гүйцэтгэсний дараа сэтгэлзүйн ярилцлага, эмчилгээг зохион байгуулахыг;


Албан даалгаврын хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг заалт тус бүрээр гарган хавсралтад заасан гүйцэтгэсэн ажлын мэдээний хамт хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, жилийн эцсийн тайланг 11 дүгээр сарын 07-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах сургалтын газарт ирүүлэх.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн
01 албан даалгаврын хавсралт



**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН 2025 ОНЫ
"ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ" АЛБАН ДААЛГАВРЫН ХҮРЭЭНД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН МЭДЭЭ**

№	Үзүүлэлт		Харьяа газар	
			НОБГ	
	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн мэдээ	ОБГ, хэлтэст хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн эсэх (тийм, үгүй)		
		ГТУАА, ЭХАА, салбар, бүлэгт хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн эсэх (тийм, үгүй)		
		Эрсдэлийн зэрэг (өндөр/дунд/бага)		
		Илэрсэн зөрчлийн тоо		
		Зөрчлийг арилгуулсан тоо		
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2 дахь заалтыг байгууллагын төсөвт суулгасан эсэх	Тийм/үгүй		
		Суулгасан хөрөнгө		
		Зарцуулсан хөрөнгө		
	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын тоо			
	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад зарцуулсан хөрөнгө			
	Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх орон тооны бус комисс байгуулсан эсэх (огноо, дугаар)			
	Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийн тоо			
	Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийн сургалт	Тоо		
		Цаг		
		Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо		
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, дүрмийн сургалт	Тоо		
		Цаг		
		Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо		
	ХАБЭА хариуцсан мэргэжилтнийг	Тийм/үгүй		

	сургагч багшийн сургалтад хамруулсан эсэх	Хамрагдсан алба хаагчдын тоо		
		сургагч багшийн гэрчилгээ авсан эсэх		
	Шинээр томилогдсон болон ажлын байр өөрчлөгдсөн алба хаагчийн сургалт, зааварчилгаа	Шинэ томилогдсон алба хаагчийн тоо		
		Сургалт зохион байгуулсан тоо		
		Сургалт зохион байгуулсан цаг		
		Сургалтад хамрагдсан алба хаагчдын тоо		
		ХАБЭА-н дүрмийн зааварчилгаа өгсөн АХ-ийн тоо		
	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Үзлэг хамрагдах ёстой		
		Үзлэгт хамрагдсан тоо		
		Үзлэгт хамрагдаагүй шалтгаан		
	Мэргэжлээс шалтгаалсан өвчний үзлэг хийлгэсэн эсэх	Үзлэг хамрагдах ёстой		
		Үзлэгт хамрагдсан тоо		
	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт	Тарваган тахал		
		Томуу, томуу төст өвчин		
		Элэгний В, С		
	Хачигт халдвар	1-р тун		
		2-р тун		
		3-р тун		

Жич: Албан даалгаврын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын мэдээний хүснэгтийг **Ms Excel** үйлдлийн систем дээр хийх, тоон мэдээллээс бусад ажлын тайланг **MsWord** үйлдлийн систем дээр хийж, тайланг t.ulemj@gmail.com хаягаар ирүүлэх

Холбогдох мэдээллийг: Гамшгаас хамгаалах сургалтын газрын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад Т.Үлэмж (утас:88051062)-ээс тодруулах.